

ЖУУЛЧНЫ ХӨТӨЧ ТАЙЛБАРЛАГЧИД ҮНЭМЛЭХ ОЛГОХ ШАЛГАЛТЫН АРГА ХЭЛБЭР, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СОРИЛ

2025 ОНЫ 1-Р УЛИРАЛ

Шалгалтын зорилго: Аялал жуулчлалын тухай хуулийн 10.4 болон Жуулчны хөтөч тайлбарлагчид үнэмлэх олгох, сунгах, сэргээх, түдгэлзүүлэх, хүчингүй болгох болон мэргэжлийн ур чадварын ангилал, зэрэглэл тогтоох журам -ын 3.4-д заасныг үндэслэн жуулчны хөтөч- тайлбарлагчийн эзэмшвэл зохих мэдлэг, ур чадварыг үнэлж, цаашид мэргэжлийн үнэмлэхтэй болгоход тус шалгалтын зорилго оршино.

Дээрх зорилгын хүрээнд “Жуулчны хөтөч тайлбарлагчид үнэмлэх олгох, сунгах, сэргээх, түдгэлзүүлэх, хүчингүй болгох болон мэргэжлийн ур чадварын ангилал, зэрэглэл тогтоох журмын 3.9-д заасны дагуу шалгалт нь Ур чадварын шалгалт (Нийт онооны 50 хүртэл хувь), Ерөнхий мэдлэгийн шалгалт (Нийт онооны 50 хүртэл хувь) гэсэн 2 үе шаттай бөгөөд Ур чадварын шалгалтад 60 болон түүнээс дээш оноо авч тэнцсэн шалгуулагч 2-р үе шат болох Ерөнхий мэдлэгийн шалгалтад хамрагдсан.

1. Ур чадварын шалгалтын гүйцэтгэлийг Монголын Үндэсний музей болон Чингис хаан Үндэсний музейд шалгуулагч тус бүрд дараах үзмэрүүдээс 2-ыг сонгон, гадаад хэлээр тайлбарлуулж үнэллээ.

Чингис хаан Үндэсний музейд

Гуравдугаар давхар. Эртний төрт улсын танхим

- Дайчин эрийн арьсан дээл
- Домгийн амьтны чимэглэлтэй духавч
- Овгийн тамгатай шагай

Дөрөвдүгээр давхар. Монгол нутаг дах эртний нүүдэлчдийн төрт улсын танхим

- Ширмэн индүү
- Чойрын хүн чулуу

Тавдугаар давхар. Их монгол улсын танхим

- Галт шувууны дүрслэлтэй алтан бугуйвч
- Богтаг малгай

Долоодугаар давхар. Чингис хааны угсааны хаад, язгууртны танхим

- Халхын Абтай сайн хаан (Хуулбар зураг)
- Нэрчүгийн гэрээ (Хуулбар)
- Түшээт хааны алтан шүншигтэй тамга

Монголын Үндэсний музейд

Нэгдүгээр давхар. Эртний улсуудын танхим

- Нар, саран чимэглэл
- Хүннү, Сяньбийн үеийн булш (Айрагийн гозгор олдворт газар)

Хоёрдугаар давхар. Уламжлалт хувцас, гоёл чимэглэлийн танхим

- Энхрий хүүхдийн хувцас, эдлэл (2 үзмэрийг хоёуланг нь эсвэл аль нэгийг нь төвлөн ярьж болно.)
- Торгууд хувцас, гутал, хэрэглэл

Гуравдугаар давхар. Уламжлалт соёлын танхим

- Бөөгийн хувцас, хэрэглэл
- Ганлин

Гуравдугаар давхар. Уламжлалт ахуйн танхим

- Уламжлалт хөсөг, тээвэр (зураг)
- Тэмээний ногт, хэрэгсэл сэлт

Гуравдугаар давхар. Социалист Монгол улс

- Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Төрийн сүлд (1940 он) хатгамал
- ЗХУ, БНМАУ-ын сансрын хамтарсан нислэгт зориулсан сансрын нисгэгчдийн гарын үсэгтэй монгол улсын төрийн далбаа (1981 он)

Ингэхдээ тухайн шалгуулагч хөтөч-тайлбарлагчийн

Хөтөч тайлбарлагчийн техник эзэмшсэн байдал

- Зочдод тайлбарлахдаа ярианы хурдаа тохируулж, үг хэллэгээ тод хэлж, дуу хоолой далайцтай байж, зочидтой холбоо тогтоож чадаж буй эсэх
- Музейн аяллын үед үзмэрээс үзмэрт шилжих үед шат, босго, халтиргаа гулгааг сануулж, зочдыг аюулгүй аялахад анхаарал тавьж буй эсэх, мөн группыг оновчтой байрлуулж, хүн тус бүрд анхаарал хандуулж, сонор сэрэмжтэй байгаа эсэх,
- Асуултад техникийн дагуу товч тодорхой хариулж буй эсэх,
- Шалгалтын үеэр цэвэрхэн хувцаслаж, биеэ соёлтой авч явж, бусаддаа төвөг удахгүй хүндэтгэлтэй хандаж, хоцролгүй ирж, мэргэжлийн хандлага харуулж чадаж буй эсэхийг онцгойлон шалгана.

Мэдээлэл хүргэх чадвар эзэмшсэн байдал

- Өгөгдсөн хугацаанд гол мэдээллийг сонирхолтой байдлаар, хэлний оновчтой үг хэллэг, дүрэм ашиглан ярьж буй эсэх,
 - Тайлбарыг уялдаа холбоо, цэгцтэйгээр бодит тоо баримт, сонирхолтой жишээ, судалгаагаар баяжуулан хүргэж буй эсэхийг үндсэн шалгуур болголоо.
2. **Ерөнхий мэдлэгийг сорихдоо** доор дурдсан агуулгыг багтаасан 50 сорил бүхий, тус бүр 5 хариулттай сорил бэлтгэн шалгалаа. Шалгалтын сорилыг, оновчтой хариултын хамт доор хавсаргав.
- Түүх, археологи (тестэд эзлэх хувь 20)
 - Шашин, соёл (тестэд эзлэх хувь 20)
 - Газарзүй, геологи, палеонтологи, амьтан, ургамал (тестэд эзлэх хувь 20)
 - Монгол орны нийгэм, улс төр, эдийн засаг (тестэд эзлэх хувь 20)
 - Салбарын хууль эрх зүйн орчин, мэргэжлийн ёс зүй (тестэд эзлэх хувь 20)

САЛБАР: Аялал жуулчлал

ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА: 60 минут

OHOO: 50

ЕРӨНХИЙ МЭДЛЭГИЙН СОРИЛ – 5 бүлэг сэдвийн 50 сорил

2025 ОНЫ 1-Р УЛИРАЛ

Үнэлүүлэгчийн нэр Үнэлүүлэгчийн код: | | | | | | | |

Даалгавар гүйцэтгэх удирдамж заавар:

Асуулт бүрийг анхааралтай уншиж гүйцэтгэнэ үү. Бүх асуулт 5 сонголтот хариулттай бөгөөд зөвхөн нэг хариулт нь оновчтой. Оновчтой хариулт бүр 1 оноо. Алдаатай хариултад оноо тооцохгүй.

1. Модун шаньюй юуг “Улсын үндэс” гэж сургасан бэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/
 - a. Хаан
 - b. Цэрэг арми
 - c. Агт морьд
 - d. Газар
 - e. Хааны зөвлөх түшмэд, сайд
2. Нирун улсын хүн амын үндсэн хэсэг ямар угсаатан байсан бэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/
 - a. Монгол
 - b. Уйгур
 - c. Түрэг
 - d. Манж-түнгүс
 - e. Хятад
3. Уйгур нь шашин соёлын талаар аль улстай илүү өргөн харилцаатай байсан бэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/
 - a. Согд

- b. Хятад
- c. Төвөд
- d. Иран
- e. Энэтхэг

4. Хүн төрөлхтний соёл иргэншилд Нүүдэлчдийн оруулсан хувь нэмэрт аль нь хамаарахгүй вэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Нүүдлийн мал аж ахуйг эрхлэн хөтлөх арга ухаан
- b. Цагаан идээ боловсруулах арга, технологи
- c. Арьс шир боловсруулах технологи
- d. Гол мөрний сав газраар тариалан эрхлэх технологи
- e. Байгальд ээлтэй амьдралын хэв маяг

5. Их Монгол улсын нийслэл Хархорумд 1250-аад онд олон шашны мэтгэлцээн зохион байгуулж байсныг нэгэн элч өөрийн нүдээр үзэж тэмдэглэн үлдээжээ. Тэр элчийн нэр хэн бэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Гильом де Рубрук
- b. Рашид Ад Дин
- c. Марко Поло
- d. Плано Карпини
- e. Ата Малик Жувейни

6. Монголын Ил хант улсыг үндэслэгч хэн бэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Тэмүүжин, Бөртэ нарын ууган хүүгийн хүү
- b. Тэмүүжин, Бөртэ нарын хоёрдугаар хүүгийн хүү
- c. Тэмүүжин, Бөртэ нарын гутгаар хүүгийн хүү
- d. Тэмүүжин, Бөртэ нарын отгон хүүгийн хүү
- e. Тэмүүжиний 5 дах үеийн ач

7. XV-XVII зууны Монголд улс төрийн хямрал болоход нөлөөлсөн гол шалтгаан юу вэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Хааны сүр хүч суларч, ноёдын биеэ даасан байдал бэхэжсэн
- b. "Хар тахал" гэж алдаршсан тахлаас болж эдийн засаг, нийгмийн тогтворгүй байдал үүссэн
- c. Бурхны шашны зэн урсгал Монголд хүчтэй дэлгэрсэн
- d. Хятадын Хан улсын явуулга, довтолгоон
- e. Манжийн Тэнгэр тэтгэгч хааны явуулга, довтолгоон

8. XVII зуунаас монголчууд бурхны шашинд олноор орсон шалтгаанд аль нь хамаарахгүй вэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Монгол, Төвөд хоёр улс нэгдэж нэгэн улс болох зорилготой байсан
- b. Төвөд улс монголчуудаас улс төр, цэрэг, эдийн засгийн дэмжлэг авахыг зорьсон
- c. Монголын язгууртнууд шашныг ашиглан нэр хүндээ өсгөхийг зорьсон
- d. Монголчууд дайн самуунаас залхаж, амар тайван байхыг хүссэн
- e. Монголд хутагт хувилгаад олноор тодруулж эхэлсэн

9. Монгол улсад төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоо хэзээ байсан бэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Олноо өргөгдсөн Монгол улсын үед
- b. Автономит Монгол улсын үед
- c. БНМАУ-ын үед
- d. 1990 – 2000 онд
- e. Одоо хэрэгжсээр байгаа

10. 1930-аад оны Улс төрийн хэлмэгдүүлэлтийн гадаад хүчин зүйл юу вэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Сталин, Чойбалсан нарын дотно нөхөрлөл
- b. ЗХУ ба Япон улсын геополитикийн бодлогын зөрчил
- c. Хятад дах улс төрийн тогтворгүй байдал
- d. Японы тагнуулууд Монголд ажиллаж байсан нь
- e. Япон улс Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхгүй байсан байр суурь

11. Эрдэнэзуу хийдийг хэзээ зарлиг гарган бариулсан бэ?

- a. Хятадад Чингийн төр ноёрхож байх үед
- b. Хятадад Мингийн төр ноёрхож байх үед
- c. Өндөр гэгээн Занабазар эснэсэн жил
- d. Хятадад Юанийн төр ноёрхож байх үед
- e. Хоёрдугаар богд эснэсэн жил

12. Өнөөгийн Монголд сүм хийдийн тоогоор _____ тэргүүлж байна.

- a. Бурханы шашин
- b. Христийн шашин
- c. Исламын шашин
- d. Бахайн шашин
- e. Хиндү шашин

13. Гандантэгчинлин хийдийг хэдэн онд дахин сэргээсэн бэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. 1991 он
- b. 1944 он
- c. 1960 он
- d. 1970 он
- e. 1995 он

14. Хутагт хувилгаад гэх ойлголт улсуудын соёлын хүрээнд байна. Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Энэтхэг, Хятад, Мьянмар
- b. Бутан, Төвөд, Вьетнам
- c. Монгол, Төвөд, Бутан

- d. Тайланд, Индонези, Япон
- e. Хятад, Монгол, Япон

15. Голчлон сүм хийдийн хаалганы бариулд (зарим тохиолдолд хөөрөгний мөрөнд) дүрслэгдсэн байдаг “амандаа зуусан зүйлээ буцааж гаргахгүй” бэлгэдэлтэй домгийн амьтны нэр юу вэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Нэг эвэрт
- b. Далавчтай морь
- c. Зээбад
- d. Луу
- e. Хангарди

16. Дараах археологийн дурсгалуудын аль нь Түрэг-Уйгурын үед хамаарахгүй вэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Заамарын Шороон дов дурсгал
- b. Баяннуурын Шороон бумбагар дурсгал
- c. Дорнод аймаг дах Хэрлэн барс туурь
- d. Архангайн Хашаат дах Хөшөө цайдамын дурсгал
- e. Налайхын Мэргэн Тоньюкукийн дурсгалд зориулсан гэрэлт хөшөө

17. Монгол үндэсний бөхийн дүрмээр ямар үйлдэл хийвэл унасанд (хожигдсонд) тооцох вэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Хязгаарласан талбайгаас гарсан үед
- b. Оноогоор ялагдсан үед
- c. Зөвхөн толгойгоор унасан үед
- d. Дал, өвдөг, тохой, нуруу, өгзгөөр унасан үед
- e. Гарын хуруугаар газар тулсан үед

18. Монголд кирилл үсгийг албан ёсоор хэрэглэхийн яг өмнө ямар бичиг хэрэглэх тогтоол гарч байсан бэ?

- a. Тод үсэг
- b. Соёмбо үсэг
- c. Али гали үсэг
- d. Латин үсэг
- e. Вагиндрагийн үсэг

19. 1992 онд баталсан Монгол улсын Үндсэн хуульд иргэний шүтэх бишрэх эрх чөлөөг хэрхэн хуульчилсан бэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Иргэний шашин шүтэх эрхийг хориглосон байна.
- b. Зөвхөн аль нэг шашныг шүтэхийг тулгасан байна.
- c. Бурхны шашин шүтэх эрхийг л зөвшөөрсөн байна.
- d. Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг зөвшөөрч хуульчилсан байна.
- e. 1992 оны Үндсэн хуульд энэ сэдвээр дурдаагүй.

20. “Тэлээ хурга” гэж юу гэсэн утгатай вэ?

- a. Өнчин хурга
- b. Хүзүүвчтэй хурга
- c. Ихэр хурга
- d. Хоёр эх хөхдөг хурга
- e. Сэтэртэй хурга

21. "Өндөг хулгайлагч" буюу Oviraptor үлэг гүрвэлийн чулуужсан өндөг аль газраас олдсон бэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Өмнөговь, Нэмэгт
- b. Өмнөговь, Баянзаг
- c. Өвөрхангай, Өөш
- d. Хэнтий, Бэрхийн уурхай
- e. Дундговь, Их газрын чулуу

22. Дэлхийд алдартай "Ноцолдож буй үлэг гүрвэл" олдвор ямар хоёр үлэг гүрвэлээс бүрддэг вэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Вэлосираптор болон протоцератопс
- b. Тарбозавр болон завролофус
- c. Овираптор болон вэлосираптор
- d. Бактрозаурус болон дейнохейрус
- e. Бактрозаурус болон завролофус

23. Монгол палеонтологич, мэргэжилтнүүд хөтөч, газарчны хувиар бус судлаачийн хувиар оролцсон анхны хамтарсан судалгаа аль нь вэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. 1920-оод оны үед хийсэн Рой Чапман Эндрюсийн ахалсан экспедиц
- b. 1940-1950-аад оны үед хийсэн Ефремовын ахалсан экспедиц
- c. 1960-1970-аад оны үед хийсэн Монгол-Польшийн экспедиц
- d. 1970-аад оноос Хэрмэн цав орчмоор хийж эхэлсэн Зөвлөлт-Монголын экспедиц
- e. 1993-2010 үед хийсэн Монгол-Японы экспедиц

24. Аль төрлийн чулуулаг дээр эртний амьтан, ургамлын үлдвэр олддог вэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Бялхмал
- b. Гүний
- c. Тунамал
- d. Метаморф
- e. Алин дээр нь ч олдохгүй.

25. Хангайн нуруу аль хоёр ай савыг заагладаг вэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Хойд мөсөн болон Номхон далайн ай сав
- b. Төв Азийн гадагш урсгалгүй ай сав болон Хойд мөсөн далайн ай сав
- c. Төв Азийн гадагш урсгалгүй ай сав болон Номхон далайн ай сав
- d. Атлантын далай болон Номхон далайн ай сав

е. Аль нэг ай савын хагалбар болдоггүй.

26. Монгол орны тектоникийн үндсэн хавтан аль нь вэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Евразийн хавтан
- b. Номхон далайн хавтан
- c. Энэтхэгийн хавтан
- d. Өмнөд Америкийн хавтан
- e. Гренландын хавтан

27. Монгол орны галт уулсын идэвхтэй бүс хаана байрладаг вэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Хангайн нуруу
- b. Говь
- c. Хэнтийн нуруу
- d. Алтайн уулс
- e. Увс нуурын хотгор

28. Дэлхий дээр 100 хүрэхгүй тоотой үлдсэн Монголын ховор амьтан аль нь вэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Тахь
- b. Мазаалай
- c. Халиун буга
- d. Бөхөн
- e. Хулан

29. Тул загасны талаарх дараах тодорхойлолтын аль нь буруу вэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Увс, Хяргас нууруудаас тул загас агнаж болно.
- b. Тул загасны жараахай 2-4 см орчим хэмжээтэй.
- c. Тул загас зөвхөн цэнгэг уст голд амьдарна.
- d. Тул нь махчин загас бөгөөд жижиг загас, сэг зэмээр хооллоно.
- e. Тул загасыг барихад тусгай зөвшөөрөл шаардлагатай.

30. Монголчуудын нийтлэг мэдэх цөмдөг самрыг аль модноос түүдэг вэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Нарс
- b. Хус
- c. Хуш
- d. Шинэс
- e. Тоорой

31. 2024 оны мал тооллогын урьдчилсан дүнгээр Монгол улсад 57,6 сая мал тоологдлоо. Малын төрлөөр задалсан дараах тодорхойлолтын аль нь хамгийн оновчтой байна вэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Ямааны тоо толгой хониныхоос олон
- b. Нийт малын 11 орчим хувийг үхэр сүрэг эзэлж байна.
- c. 2024 онд таван хошуу малаас зөвхөн адууны тоо толгой л өсөлттэй гарсан.
- d. Нэг монгол хүнд 2 толгой адуу оногдож байна.
- e. 2024 онд тэмээний тоо толгой 1 саяд хүрчээ.

32. 2023 оны Статистик мэдээллээр дараах тодорхойлолтуудын аль нь үнэн бэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Хүн амын дундаж наслалт эрэгтэй 67.6, эмэгтэй 76.8 байна.
- b. Хүн амын дунд эзлэх эрэгтэй/эмэгтэй хүмүүсийн тооны харьцаа 60/40 байна.
- c. Хүн амын дундаж наслалт 68.1 байна.
- d. Хүн амын дунд гадаад иргэд 11%-ийг эзэлж байна.
- e. Энэ дунд үнэн тодорхойлолт алга.

33. Сүүлийн 5 жилийн байдлаар монголчуудын нас баралтын гол шалтгаан болж байгаа өвчин аль нь вэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Хавдар
- b. Хоол боловсруулах тогтолцооны өвчин
- c. Зүрх судасны тогтолцооны өвчин
- d. Амьсгалын тогтолцооны өвчин
- e. Шээс, бэлгийн тогтолцооны эмгэг, өвчин

34. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулиар дараах тодорхойлолтын аль нь оновчтой вэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Монгол улсад хувийн хэргээр оршин суух гадаад иргэний тоо нь Монгол улсын харъяат хүн амын 3%, үүний дотор нэг улсын иргэн 1% хүртэл байж болно.
- b. Монгол улсад хувийн хэргээр оршин суух гадаад иргэний тоо нь Монгол улсын харъяат хүн амын 5%, үүний дотор нэг улсын иргэн 3% хувь хүртэл байж болно.
- c. Монгол улсад хувийн хэргээр оршин суух гадаад иргэний тоо нь Монгол улсын харъяат хүн амын 7%, үүний дотор нэг улсын иргэн 5% хүртэл байж болно.
- d. Монгол улсад хувийн хэргээр оршин суух гадаад иргэний тоо нь Монгол улсын харъяат хүн амын 10% хүртэл, үүний дотор нэг улсын иргэн 5% хүртэл байж болно.
- e. Монгол улсад ийм төрлийн хуулийн зохицуулалт байхгүй.

35. 2023 онд Монгол улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн 68.871,7 тэрбум төгрөг байжээ. Үүний хамгийн ихийг аль салбар үйлдвэрлэсэн бэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур
- b. Уул уурхай, олборлолт
- c. Боловсруулах үйлдвэрлэл
- d. Барилга
- e. Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ

36. 2024 онд Монголыг зорин ирсэн гадаадын жуулчдын тоо хэд байсан бэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. 150.000-300.000
- b. 300.001 – 450.000
- c. 450.001 – 600.000
- d. 600.001 – 750.000
- e. 750.001 – с дээш

37. НҮБ-ын энхийг сахиулах хүчинд зүтгэж буй АНУ-ын цэргийн анги Монгол улсын нутаг дэвсгэрт байрлаж, үйл ажиллагаа явуулах хүсэлтээ Монгол улсын ерөнхийлөгчид уламжилжээ. Үндсэн хуульд зааснаар уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Хил нэвтрүүлэх асуудлыг Улсын их хурал хууль гаргаж шийдвэрлэнэ.
- b. Ямар ч тохиолдолд гадаадын цэргийн ангийг Монгол улсын хил нэвтрүүлэхийг хориглоно.
- c. Ерөнхийлөгч зарлиг гаргаж шийдвэрлэнэ.
- d. Засгийн газар хуралдаж, Ерөнхий сайд шийдвэрлэнэ.
- e. Батлан хамгаалахын сайд тушаал гаргаж шийдвэрлэнэ.

38. Дараах тодорхойлолтуудын аль нь зөв бэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Монгол улсын нутаг дэвсгэрт байнга оршин суугч гадаадын иргэн Монгол улсад газар өмчлөх эрхтэй.
- b. Монгол улсын иргэн Монгол улсын нутаг дэвсгэрт өмчилж авсан газраа дурын иргэнд худалдан борлуулах эрхтэй.
- c. Монгол улсын нутаг дэвсгэрт байнга оршин суугч гадаадын иргэн Монгол улсад газар эзэмших болон ашиглах эрхтэй.
- d. Монгол улсын иргэд Монгол улсад газар эзэмших эрхгүй.
- e. Монгол улсын нутаг дэвсгэрт байнга оршин суугч гадаадын иргэн Монгол улсад газар өмчлөх эрхгүй.

39. Монгол улсын Засгийн газар 2025 оны 4р сараас Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэхээр болсон. Ингэхдээ одоо байгаа хэмжээнээс хэдэн хувиар өсгөх вэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. 5%
- b. 10%
- c. 15%
- d. 20%
- e. 25%

40. Дараах аймгуудаас хүн ам хамгийн цөөтэй нь аль вэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Баян-Өлгий
- b. Орхон
- c. Дархан-Уул
- d. Дундговь

е. Өмнөговь

41. Аялал жуулчлалын тухай хуульд зааснаар “жуулчинд үндэсний түүх, соёл, өв уламжлал, зан заншил, байгаль, газар зүйн онцлог болон шаардлагатай бүх мэдээллийг хүргэж, аяллыг хөтлөн явуулах энэ хуульд заасан шаардлага хангасан хүн”-ийг хэн гэх вэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Аяллын хөтөч
- b. Аяллын хөтөч тайлбарлагч
- c. Аяллын хөтөч орчуулагч
- d. Жуулчны хөтөч-тайлбарлагч
- e. Жуулчны хөтөч

42. Аль нь аяллын агентын гүйцэтгэх үйл ажиллагаанд хамаарахгүй вэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Виз авахтай холбоотой болон аяллын бусад бичиг баримтын бүрдүүлэлт хийх
- b. Тээврийн хэрэгслээр зорчих тасалбарын захиалга хийх, тийз худалдан борлуулах
- c. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төлөвлөн бүрдүүлж шууд борлуулах, аялал зохион байгуулах
- d. Тур операторын болон аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээг зуучлан худалдан борлуулах үйл ажиллагаа
- e. Энд дурдсан бүх үйл ажиллагааг тур агент гүйцэтгэж болно.

43. Аялал жуулчлалын тухай хуульд зааснаар өндөр уулын авиралт, ан, усны гүнд шумбах, нисдэг тэрэгний аялалд оролцох жуулчин, жуулчны хөтөч-тайлбарлагч, мэргэшсэн сургагч багш, зааварлагч нь ----- заавал хамрагдана. Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Богино хугацааны мэргэжлийн сургалтад
- b. Урт хугацааны мэргэжлийн сургалтад
- c. Гэнэтийн ослын даатгалд
- d. Хариуцлагын даатгалд
- e. Аль нь ч биш

44. Аялал жуулчлалын тухай хууль болон холбогдох журмын дагуу гадаад улсын иргэн Монгол улсад жуулчны хөтөч-тайлбарлагчаар ажиллаж болох уу? Дараах тодорхойлолтын аль нь оновчтой вэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. Монгол хүнтэй гэрлэлтээ батлуулсан бол, өөр шалгуургүйгээр ажиллаж болно.
- b. Жуулчны хөтөч-тайлбарлагч мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамрагдсан бол, өөр шалгуургүйгээр ажиллаж болно.
- c. Гадаад улсын иргэн Монголд жуулчны хөтөч-тайлбарлагчаар ажиллах эрх үүсээгүй.
- d. Монгол улсад хөрөнгө оруулагчаар бүртгүүлсэн бол, өөр шалгуургүйгээр жуулчны хөтөч-тайлбарлагчаар ажиллаж болно.
- e. Монгол улсад 5 жил болон түүнээс дээш хугацаагаар оршин сууж, монгол хэлний түвшин тогтоох шалгалтад тэнцэж, жуулчны хөтөч-тайлбарлагчийн үнэмлэх авсан бол болно.

45. Жуулчны хөтөч-тайлбарлагчид мэргэжлийн үнэмлэх олгох шалгалт зохион байгуулах өдрийн товыг шалгалт эхлэхээс хэд хоногийн өмнө олон нийтэд нээлттэй мэдээлж, нийтийн эрхзүйн хуулийн этгээдийн цахим хуудсанд байршуулдаг вэ?

- a. 30 хоногийн өмнө
- b. 14 хоногийн өмнө
- c. 45 хоногийн өмнө
- d. 7 хоногийн өмнө
- e. Дээрх бүгд буруу

46. Жуулчны хөтөч тайлбарлагчид үнэмлэх олгох, ангилал зэрэглэл тогтоох шалгалт ямар шалгалтаас бүрдэх вэ?

- a. Ур чадварын шалгалт болон ерөнхий мэдлэгийн шалгалт
- b. Зөвхөн ур чадварын шалгалт
- c. Зөвхөн ерөнхий мэдлэгийн шалгалт
- d. Гадаад хэлний болон ур чадварын
- e. Дээрх бүгд буруу

47. Жуулчны хөтөч тайлбарлагчид олгох үнэмлэх хэдэн жилийн хугацаанд хүчинтэй вэ?

- a. 2 жил
- b. 3 жил
- c. 5 жил
- d. 4 жил
- e. Хугацаагүй

48. Жуулчны хөтөч тайлбарлагч нь ямар 2 ангилалтай вэ?

- a. Ерөнхий аяллын ба явган аяллын гэж 2 ангилна
- b. Явган аяллын ба тусгай аяллын гэж 2 ангилна
- c. Уулын аяллын болон ерөнхий аяллын гэж 2 ангилна
- d. Ерөнхий аяллын болон тусгай аяллын гэж 2 ангилна
- e. Тусгай аяллын болон ан ангуурын аяллын гэж 2 ангилна

49. Аялал жуулчлалын тухай хуулийн дагуу "аялал жуулчлалын нөөц" гэж юу вэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- a. аялал жуулчлалын байгууллагаас жуулчинд санал болгож байгаа аяллын явцад шаардагдах бүтээгдэхүүн, үйлчилгээг;
- b. нисэх буудал, зам, тээвэр, эрчим хүч, ус хангамж, ариун цэврийн байгууламж, улсын, олон улсын, орон нутгийн чанартай авто зам дагуух үйлчилгээний байгууламж, тэмдэг тэмдэглэгээ, харилцаа, холбоо, мэдээлэл технологийн цахим дэд бүтцийг;
- c. аялал жуулчлалын үйл ажиллагаанд ашиглах байгалийн тогтоц, амьтан, ургамал, түүх, палеонтологи, археологи, шашин, соёлын биет болон биет бус өв, өв тээгчийг;

- d. байр сууц, тээвэр, хоол үйлдвэрлэл, үзмэр, үзвэр үйлчилгээ, жуулчны мэдээллийн төв зэрэг жуулчинд зориулсан үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдийг;
- e. аялал жуулчлалын бүсийн байгалийн нөөц, түүх, соёлын дурсгалыг хамгаалах, зохистой ашиглах, сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэсэн богино болон дунд хугацааны төлөвлөгөөг;

50. Жуулчны хөтөч тайлбарлагчид үнэмлэх олгох, ангилал зэрэглэл тогтоох шалгалтад гадаадын харъяалалтай иргэн хамрагдах эрхтэй юу?

- a. Эрхтэй
- b. Эрхгүй
- c. Монгол улсын иргэншил авах шаардлатай
- d. Ази тивд байдаг улсын иргэн бол эрхтэй
- e. Дээрх бүгд буруу

ХАРИУЛТ:

1d 2a 3a 4d 5a 6d 7a 8a 9c 10b

11b 12b 13b 14c 15c 16c 17d 18d 19d 20d

21b 22a 23c 24c 25b 26a 27a 28b 29a 30c

31b 32a 33c 34a 35b 36e 37a 38e 39d 40d

41d 42c 43c 44e 45c 46a 47c 48d 49c 50a